


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 12 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-49 дүгээр долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 12 аймагт **2132** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 2132 тохиолдлын 96% /2032/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 4% /100/ нь орон нутагт (Баян-Өлгий /40/, Дорнод /4/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /4/, Дархан /4/, Говь-Алтай /3/, Баянхонгор /1/, Дундговь /1/, Хэнтий /1/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **654** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **49** ДҮГЭЭР ДОЛОО ХОНОГТ

(2025.11.30 – 12.6)


2025 оны эпидемиологийн 49 дүгээр долоо хоногт 14 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 83.3 хувиар, 5 жилийн дунджаас 76.3 хувиар тус, тус буурсан үзүүлэлттэй байна.



ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ


Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-49 дүгээр долоо хоногт нийт 1330** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.

760 Эмнэлгийн тусламж авч буцсан	570 Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан	0 Нас барсан	Эрэгтэй 47%	Эмэгтэй 53%
--	---	------------------------	-----------------------	-----------------------



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 49 дүгээр долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **35** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 119 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 307 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 49 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	0	13	13
2	Эмийн хордлого	11	11	22
Нийт		11	24	35

Нийт 35 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 22 (62.9%) нь эмийн хордлого, 13 (37.1%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 24 (68.6%) тохиолдол, санаатай хордлого 10 (31.4%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.